

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

671.	Хэлэлцээрт нэгдэн орох тухай	2473
------	------------------------------	------

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

672.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 61	2474
------	----------------------------	-----------	------

673.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 62	2474
------	----------------------------	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

674.	Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 212	2475
------	---	------------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

675.	Орон тооны ажлын албадын тухай	Дугаар 117	2476
------	-----------------------------------	------------	------

676.	“Үйлдвэржилтийн шинэ эрин үе” зарласныг дэмжих тухай	Дугаар 118	2478
------	---	------------	------

677.	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 121	2479
------	--	------------	------

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
 хот

ХЭЛЭЛЦЭЭРТ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод 2010
оны 9 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан “Авлигын эсрэг олон улсын

академийг олон улсын байгууллага болгон үүсгэн байгуулах тухай хэлэлцээр"-т Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газраас 2011 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд Хүнсний тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Очирбат, Д.Арвин, Д.Оюунхорол, Ж.Батсуурь нараас 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд Хүний дархлалын олдмол хомсдолын вирусын халдварт, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Садар самуун явдалтай тэмцэх тухай



хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4, 32.6, 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Цогийн Очийг Хэнтий аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Цэрэннадмыдын Батсүрэнг Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Ерөнхий шүүгчийн, Батаагийн Гэрэлмааг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Цэрэнчимэдийн Мөнхтулгыг Өмнөговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Төмөрбаатарын Өсөхбаярыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Лувсандоржийн Одончимэгийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Шагдарсүрэнгийн Гандансүрэнг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Доржийн Battulgaa, Цогтбаярын Урангуяа нарыг Өмнөговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Баярын Мөнх-Эрдэнийг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон тул Цогийн Очийг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Цэрэннадмыдын Батсүрэнг Дорнод аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Цэрэнчимэдийн Мөнхтулгыг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Төмөрбаатарын Өсөхбаярыг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 117

Улаанбаатар
хот

Орон тооны ажлын албадын тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан ажил үүргийн давхардлыг арилгаж шат дамжлагыг цөөлөх, давхар бүтэц бий болгохгүй байх зорилгоор Хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн явцад хяналт тавих үүрэг бүхий орон тооны зөвлөл, Хөрөнгө оруулалтын зөвлөлдөх зөвлөлийн ажлын алба, Орон сууц хөгжүүлэх сангийн ажлын алба, Чөлөөт бүсийн зөвлөлийн ажлын алба, “Төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах, нэгдсэн бодлогоор хангах чиг үүрэг бүхий Үндэсний хорооны ажлын алба (Төв), “Ногоон хэрэм” Үндэсний хөтөлбөрийн удирдах зөвлөлийн ажлын алба, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хорооны ажлын алба, Сангийн яаман дахь Ядуурлын судалгааны нэгж, Хүний хөгжлийн сангийн ажлын албыг тус тус татан буулгасугай.

2. Дээр дурдсан албадыг татан буулгасантай холбогдуулан чиг үүргийг нь тухайн асуудлыг эрхэлсэн нэгж, ажилтанд хариуцуулахыг холбогдох сайд нарт даалгасугай.

3. Ойн үндэсний хороо, Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын үүргийг яамныхаа эрхэлсэн нэгж, ажилтанд хариуцуулж орон тоог нь цомхотгохыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд даалгасугай.

4. Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд усны нэгдсэн бодлого, газар зохион байгуулалтын асуудал хамаарах болсонтой холбогдуулан Усны үндэсний хорооны ажлын албаны орон тооны дээд хязгаарыг 9, Газрын шинэгэлийн үндэсний хорооны ажлын албаны орон тооны дээд хязгаарыг 5 байхаар тус тус тогтоосугай.

5. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасан ажлын албадын 2012 оны үйл ажиллагааны зардлыг төсвийн багцаасаа санхүүжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт, 2013 оны үйл ажиллагааны зардлыг татан буугдсан ажлын албадын үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан болон холбогдох сайд нарт үүрэг болгосугай.



6. Дараахь арга хэмжээг авч дүнг Засгийн газрын хуралдаанд оруулахыг сайд нарт даалгасугай:

-Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг нэгтгэх, цэгцлэх ажлын хүрээнд өөрийн эрхлэх асуудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн ажлын албадын орон тоог оновчтой тогтоох, цөөрүүлэх;

-Засгийн газрын шийдвэрээр байгуулсан зарим Үндэсний хороо, зөвлөлийн дэргэд орон тооны ажлын алба байгуулсан, ажилтан ажиллуулсан тушаал, шийдвэрээ хянаж үзэх.

7. Химиин хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын орон тоо хасагдсантай холбогдуулан “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай” Засгийн газрын 2006 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор баталсан 1 дүгээр хавсралтын “Нарийн бичгийн дарга-Орон тооны” гэснийг “…Нарийн бичгийн дарга-Химиин хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга” гэж өөрчилсүгэй.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөтөлбөр шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 248 дугаар тогтоолоор баталсан “Ойн тухай үндэсний хөтөлбөр”-ийн Долдугаар бүлгийн 1 дэх заалтын “Хорооны нарийн бичгийн дарга нь орон тооны ажилтан байна” гэснийг, “Хөтөлбөр, журам батлах тухай” Засгийн газрын 2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 58 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан, мэдээ гаргах журам”-ын 7, 8 дахь заалт, “Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор баталсан “Ногоон хэрэм” Үндэсний хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 1-ийн “б” заалтын 2 дахь өгүүлбэр, “Орон тооны хязгаарыг баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 220 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг, “Дүрэм батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2001 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 214 дүгээр тогтоол, “Бүтэц батлах тухай” Засгийн газрын 2004 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 96 дугаар тогтоол, “Зөвлөл байгуулах тухай” Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 53 дугаар тогтоол, “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 40 дүгээр тогтоол, “Үндэсний хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2008 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 289 дүгээр тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ний

өдрийн 197 дугаар тогтоол, “Үндэсний хорооны ажлын алба байгуулах тухай” Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 209 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.САЙХАНБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 118

Улаанбаатар
хот

“Үйлдвэржилтийн шинэ эрин үе” зарласныг дэмжих тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэржилтийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам болон хувийн хэвшил, мэргэжлийн холбоод хамтран “Үйлдвэржилтийн шинэ эрин үе” зарласныг дэмжсүгэй.

2. Боловсруулах аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомж болон тэргүүн ээлжинд дэмжин хөгжүүлэх үйлдвэрлэлийн төсөл, шинээр байгуулах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх үйлдвэрүүд, тэдгээрийн байршлын талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, тодорхой санал, төслийг энэ оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД

Х.БАТТУЛГА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар
хот

Төрөөс тэмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Тэмөр замын тээврийн тухай хуулийн 6.2, 9.1.1, 9.1.2, Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын 2.2, “Төрөөс тэмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 2.2.3, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32, 2012 оны 07/04 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.2-т заасан эхний үе шатанд барьж эхлэх тэмөр замын суурь бүтэц, 3.2.4-т заасан 2 дахь үе шатанд барьж эхлэх тэмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой тэмөр замын суурь бүтэц гэж үзсүгэй.

2. Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдол бүхий тэмөр замын суурь бүтцийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулах зорилгоор энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан тэмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Монголын тэмөр зам” ТӨХК-д олгосугай.

3. Төрөөс тэмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын I болон II үе шатанд барих тэмөр замын суурь бүтцийг барих төслийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай хамтарсан тусгай зориулалтын компани байгуулах замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг “Монголын тэмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Батзаяа)-д даалгасугай.

4. 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдөр “Дорнын тэмөр зам” ХХК болон “Монголиантранс Лайн” ХХК-тай байгуулсан “Сайншанд-Тавантолгой” чиглэлд тэмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг, “Энержи Ресурс” ХХК болон “Энержи Ресурс Рэйл” ХХК-тай байгуулсан “Ухаахудаг-Гашуунсухай” чиглэлд тэмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг тус тус цуцлах арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд А.Гансух, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай.



5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан “Дорнын төмөр зам” ХХК болон “Монголиантранс Лайн” ХХК, “Энержи Ресурс” ХХК болон “Энержи Ресурс Рэйл” ХХК, сонирхсон бусад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж төслийг хамтран хэрэгжүүлэх бүтэц, хөрөнгө оруулалтын хэмжээ, нөхцөлийг тохиорох, энэ тогтоолын 4 дүгээр зүйлд заасан компаниудын төмөр замын төсөлд оруулсан хөрөнгө оруулалтын зардлыг 3 дугаар зүйлд заасан тусгай зориулалтын компанийд оруулах хөрөнгө оруулалтад тооцож хувьцаа эзэмшүүлэх, эсхүл буцаан олгох талаар хэлэлцээ хийхийг Зам, тээврийн сайд А.Гансүхэд даалгасугай.

6. Ухаахудаг-Гашуунсухайтын чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ байгуулаад байсан хуулийн этгээдийн уг чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглан жилд тээвэрлэх ачааны хэмжээ бүхий тээврийн эрхийг олгох, одоогийн байдлаар ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдийг цаашид үргэлжүүлэн ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Зам, тээврийн сайд А.Гансүхэд даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 93 дугаар тогтоол, “Төмөр замын суурь бүтцийг барих концессын гэрээний тухай” Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 161 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

А.ГАНСҮХ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 14003